

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар

2023 оны эхний хагас жил

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
МУ-ын хууль							
1	1	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-12-22 Дугаар 2017.02.01	18.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар хөтөлбөр баталж, хэрэгжилтэд хяналт тавих; (18.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	-	Х.Б	Х.Б	
	2		18.1.2.. Засаг даргын өргөн мэдүүлснээр харьяалах нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зардлыг тухайн орон нутгийн төсөвт тусган батлах, гүйцэтгэлийн тайланг хэлэлцэх; (18.1.Аймаг,	-	Х.Б	Х.Б	

		нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)			
3		19.1.1.. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах зорилгоор Тамгын газарт Сэтгэл зүйн төвийг нээн ажиллуулж, хохирогч тус бүрийн онцлог хэрэгцээ, хохирогч сэтгэцийн гэмтлийг харгалзан тухайн үе шатанд тохирсон сэтгэл зүйн боловсрол олгож, үйлчилгээ үзүүлж эхлээд байна. Аймгийн цагдаагийн газартай хамтран " Гэр бүлийн нуугдмал хүчирхийллийг илрүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх" баг -7 хоног арга хэмжээний төлөвлөгөөг гарган Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 9-н багийн эрсдэлт цэгүүдэд шөнийн эргүүл хийж архины хамааралтай гишүүнтэй өрх болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх магадлалтай нийт 68 өрхөөр орж, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлан, яриа таниулга хийж ажиллалаа. Цаашид холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах ажлыг зохион байгуулах төлөвлөн ажиллаж байна.	70%	70%
4		19.1.2.. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; (19.1.Бүх шатны	"Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран сум, багийн хамтарсан багийн дарга, нарийн бичиг нарийг чадавхжуулах сургалтад хамруулсан. Аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 6 дугаар	100%	100%

		Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	сарын 21-ний өдөр " Хүүхэд хамгаалал ба эрсдэл тодорхойлох" сургалтыг хамтарсан багийн дарга нарийн бичиг, хэсгийн байцаагч, эмч нарын сургалтыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Хамтарсан багийн үйл ажиллагаанд 5,0 сая төгрөг төсөвлөсөн бөгөөд тайлант хугацаанд сургалт, үйл ажиллагааны зардалд 2.0 сая төгрөг зарцуулаад байна. Хамтарсан багийн гишүүдийн чадавхи нэмэгдэж, кейс барагдуулалтын хувь 87,5 байна.			
5		19.1.4.. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд туссан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зориулж 165000000 төгрөг төсөвлөн сумын ИТХ-ын 2022 оны 15/10 тоот тогтоолоор батлуулан ажиллаж байна.	100%	100%	
6		19.1.5.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах;	Сумын ИТХ-ын 2022 оны 15/10 тоот тогтоолоор сумын 2023 оны төсвийг баталж, 2023 онд сумын хамтарсан багийн үйл ажиллагаа болон хохирогчид үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээг хийх, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэхэд зориулан Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардалд	100%	100%	

		(19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	5,000,000 төгрөгийг батлуулан ажиллаж байна.			
	7	19.1.6.. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх; 19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:	Сумын Засаг даргын 2023 оны А/117 тоот захирамжаар сумын Засаг даргын тамгын газрын дэргэд " Сэтгэл зүйн төв" байгуулагдсан. Тус төвд ажиллах сэтгэл зүйчтэй хамтран ажиллах гэрээг 2023 оны 6 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн байгуулан ажиллаж байна. Тус Тамгын газар нь үйлчилгээний нэгдсэн төвийн байранд хуулийн дагуу зөвлөгөө өгөх нэг өрөө, төв байранд " Сэтгэл зүйн төв "-үүдийг тус тус тохижуулан гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийлэлд өртсөн хохирогч иргэдэд зөвлөгөө зөвлөмж үзүүлэх боломж бүрдсэн. 6 дугаар сард дээрх төвүүдээр 4,5 дугаар багийн нийт 12 иргэнд үйлчилгээг үзүүллээ.	100%	100%	
	8	19.1.7.. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)	Сум багийн хамтарсан багийн дарга нарийн бичиг нарийг чадавхжуулах сургалтыг Монгол өрх сэтгэл зүйн хүрээлэнтэй 1 сая төгрөгийн сургалтын гэрээг байгуулж хамтран " Хариуцлагатай хамтарсан баг " сургалтыг хамтарсан багийн дарга нарийн бичиг, хэсгийн байцаагч, эмч, сургуулийн нийгмийн ажилтан нарт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийт хамтарсан багийн нийт 21 гишүүн хамрагдлаа.	100%	100%	
	9	19.1.8.. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ	2023 оны Аймгийн ИТХ-аас "Хүүхдийн хөгжил хамгаалал"-ын жил болгон зарласан. Аймгийн Цагдаагийн байгууллага, Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран "Анзаар"	100%	100%	

			<p>чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах; (19.1.Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:)</p>	<p>аяны нээлтэд оролцлоо. Мөн Анзаар аяны нээлтийн үйл ажиллагаа болон сургалтыг Ерөнхий боловсролын сургуулийн багш, ахлах ангийн сурагчдад зохион байгууллаа. Сургалтад Ерөнхий боловсролын 4-н сургуулийн 128 багш, ахлах ангийн 480 хүүхэд хамрагдаж мэдээлэл авсан. 2023 онд Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газар нь өөрийн харьяаны төсөвт болон Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар ӨЭМТ-үүдийн захирал эрхлэгч нартай хамтран ажиллах зөвлөгөөнийг зохион байгуулж тусгай захиалгат бүтээгдэхүүнд байгууллага бүр дээр хүүхэд хамгааллын баг байгуулах, хүүхэд хамгааллын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажиллах талаар арга хэмжээ тусгасан. Мөн аймгийн цагдаагийн газартай хамтран " Гэр бүлийн нуугдмал хүчирхийллийг илрүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилсан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх" баг -7 хоног ажлын төлөвлөгөөг гарган ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу 9-н багийн эрсдэлт цэгүүдэд шөнийн эргүүлж хийж архины хамааралтай гишүүнтэй өрх болон гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх магадлалтай 68 өрхөөр явж хууль сурталчлан ажиллалаа.</p>			
2	10	<p>Төрийн албаны тухай /Шинэчилсэн найруулга/ 2017-12-07 Дугаар 2019.01.01</p>	<p>55.3. Төрийн байгууллага төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь заалт, Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12дугаар сарын 02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор "Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хяналтад авч ажилласан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд 2 чиглэлд 7 үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Хөтөлбөрийн хэрэгжилтийг сумын хэмжээнд хангах ажлын хүрээнд 1. Тус сумын Тамгын газраас 2023 оны 06 дугаар сард харъяа</p>	70%	70%	

			<p>төсөвт 18 байгууллагаар хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг ажиллаж Хүний нөөцийн нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хяналтад авч, байгууллагын онцлогт нийцүүлэн төлөвлөгөө боловсруулан ажиллах тухай чиглэл, зөвлөмжийг өгч ажилласан. Тамгын газар, 1,5,9 дүгээр цэцэрлэг тусгайлан төлөвлөгөө гаргаж хяналтад авч ажилласан байсан. 2. Тайлант оны эхний хагас жилийн байдлаар 5-н цэцэрлэг, 1 сургууль, 2 ОНӨААТҮГазрын 250 албан хаагч эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсан. 3. Сумын хэмжээнд 18 сая төгрөгийг албан хаагчдын эрүүл мэнд, түлээ нүүрс, ар гэрийн гачигдал, эмчилгээний зардал зэрэгт зарцуулсан байна. 4. Сумын хэмжээнд хоолны мөнгийг ганцхан сумын Тамгын газар олгодог бөгөөд өнгөрсөн оноос 1000 төгрөгөөр нэмэгдүүлж 1 өдрийн хоолны мөнгийг 5000 төгрөгөөр тооцон олгож байна. Бусад харъя төсөвт байгууллагууд хоолны мөнгө олгодоггүй. 5. Тамгын газар болон харъяа төсөвт бүх байгууллагууд сэтгэл ханамжийн судалгаагаа авсан бөгөөд 88 хувьтай байна. Судалгааны мөрөөр сайжруулах арга хэмжээг 5 байгууллага төлөвлөсөн, 13 байгууллага тусгайлан төлөвлөгөө боловсруулаагүй ч албан хаагчдын харилцаа хандлага, ажиллах орчин нөхцлийг сайжруулах чиглэлээр дотоод сургалтуудыг зохион байгуулж ажиллаж байна. 6. Сургалт хөгжлийн зардалд сумын хэмжээнд 1 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүний 70 гаруй хувийг худалдан авах ажиллагааны АЗ сургалтад зарцуулсан байна. Хавсралтаар Тамгын газрын тайлан хавсаргав.</p> <p>Хавсралт нийт : 16 Файл : 3 Зураг : 13</p>			
--	--	--	--	--	--	--

3	11	<p>Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай 2021-12-17 Дугаар 2022.05.01</p>	<p>8.2.3. эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;</p>	<p>Сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу дараах чиглэлээр дотоод хяналт хийж ажиллалаа. Үүнд: -Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу хадгаламжийн нэгж үүсгэн, байгууллагын архивт хугацаандаа тушаасан байдал. -Өөрийн хариуцсан салбар, эрхэлсэн ажлын хүрээний хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг бүрэн хяналтад авсан эсэх. - Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмын хэрэгжилтэд хяналт хийх. Хяналтын мөрөөр илэрсэн зөрчлийг арилгах талаар дараах зөвлөмжийг өгч ажилласан. Үүнд: <input type="checkbox"/> Жилийн эхнээс ажлаа тодорхой шалгуур үзүүлэлт, суурь түвшин болон хүрэх түвшинтэй үр дүнд суурилсан төлөвлөлт хийж, тухайн жил хэрэгжүүлэх ажил арга хэмжээг тодорхой тусган, биелэлтийг хангах талаар эрчимтэй ажиллах. үр дүнтэй зохион байгуулах, биелэлт үр дүнг тооцож ажиллах. <input type="checkbox"/> Төрийн болон орон нутгийн бодлого шийдвэрийг иргэдэд ил тод мэдээлэх, сурталчлах ажлыг тогтмолжуулах. <input type="checkbox"/> Нээлттэй мэдээллийн ил тод байдлын тухай хууль, ЗГ-ын 2022 оны 201, 352 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахад онцгой анхаарах. <input type="checkbox"/> Байгууллагын баримт бичиг нягтлан шалгах комиссыг хуралдуулж, хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтыг шинэчлэн батлах. <input type="checkbox"/> Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнийг дагаж гарсан журам, дүрмийг албан хаагчдад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах. <input type="checkbox"/> Өргөдөл, гомдол, санал хүсэлтэд дурдсан асуудал бүрийг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан үзэж, үндэслэлтэй хариу өгч, хугацаанд нь шийдвэрлэж хэвших. <input type="checkbox"/> Өргөдөл, гомдлыг</p>	100%	100%	
---	----	---	--	--	------	------	--

				<p>шийдвэрлэсэн, тохиолдолд энэ тухай хариуг биечлэн амаар буюу харилцах утсаар, эсхүл бичгийн зэрэг тохиромжтой хэлбэрээр эргэн мэдэгдэж байх.</p> <p>□ Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын өргөдөл гомдол санал хүсэлт хүлээн авах, шийдвэрлэх журмын хэрэгжилтийг ханган ажиллах. Дотоод хяналтад 5 тасгийн 28 албан хаагч хамрагдсан байна. Мөн Сумын Засаг даргын 2023 оны А/162 тоот захирамжаар томилогдсон 2 ажлын хэсэг сумын харьяаны 17 байгууллагад хяналт шинжилгээ үнэлгээг хийсэн.</p>			
	12	8.2.6. үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;	Тамгын газрын үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн актыг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хагас жилийн байдлаар дараах хууль тогтоомжийг хяналтад авч, хугацаанд нь тайлагнаж, үр дүнг тооцож ажилласан байна. Үүнд: 1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 7 заалтыг хяналтад авч, биелэлтийг 6 удаа тайлагнасан.Биелэлт 74.2 хувьтай, 2.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 заалтыг хяналтад авч, 6 удаа тайлагнасан. Биелэлт 45.0 хувьтай, 3.Аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 3 заалтыг хяналтад авч, 80 хувьтай тус тус хэрэгжсэн байна. Хагас жилийн буюу 06 дугаар сарын 28-ны байдлаар 6 хуулийн 18 заалт 1 УИХТ-ын 1 заалт 5 УИХБХТ-ын 5 заалт 2 Ерөнхийлөгчийн зарлигийн 3 заалт 1 ҮАБЗ-ийн 1 заалт 1 ҮАБЗХТ-ийн 1 заалт 3 ЗГТ-ын 3 заалт 2 ЗГХТ-ийн 3 заалт 1 ЗГАДаалгаврыг тус тус хяналтад авч хэрэгжилтийг хангаж ажиллаж тайланг хугацаанд нь илгээсэн.	100%	100%		

13		8.2.8. өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;	Тус сумын Засаг дарга Тамгын газарт хагас жилийн байдлаар 2710 өргөдөл ирсэн байна. Үүнээс бичгээр 1110, утсаар-350, цахимаар 250, амаар 1000 өргөдөл тус тус ирсэн байна. Үүнийг төрлөөр нь задалвал: 1. Шагнуулах хүсэлт- 178/ Төрийн шагнал хүссэн/- 2. Буцалтгүй тусламж-114 3. Өвс олгохыг хүссэн-940 4. Үйл ажиллагааны зөвшөөрөл-56 5. Үрчлэлт-7 6. Асран хамгаалагч тогтоох тухай-4 7. Газрын асуудлаар-26 8. 2. Малжуулах-13 9. 4. Гэр хүссэн-90 10. Улсын тэмдэгтийн хураамжийн буцаалттай холбоотой -23 11. Архивын лавлагаа хүссэн-77 12. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой кейс-92 13. Боловсролын асуудлаар хандсан-12 14. Сувилалд хамрагдах-89 15. Нохой устгуулах талаар-20 16. Түлээний дэмжлэг-50 17. Мал алга болсон-92 18. Чип төсөл-30 19. Бусад-197 Өргөдөл гомдлын барагдуулалт 97.8% байна. Өргөдөл гомдлыг улирлын мэдээг гарган аймгийн ЗДТГ-т хугацаанд нь илгээсэн.	100%	100%	
14		8.5.1. үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;	Үзүүлж буй үйлчилгээ, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалтыг гарган байгууллагын цахим хуудсанд болон самбарт байршуулсан.	100%	100%	
15		8.5.2. тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам,	Тамгын газраас тамхи худалдан борлуулах зөвшөөрөл, согтууруулах ундаа худалдан борлуулах зөвшөөрөл авахад бүрдүүлэх материалын жагсаалтыг гарган мэдээллийн самбар болон цахим	100%	100%	

		олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тусгай зөвшөөрлийн талаарх мэдээлэл, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.	хуудсандаа байршуулсан. Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн хүрээнд согтууруулах ундааны дэмжих бичиг 8, тамхины зөвшөөрөл хугацаа сунгах 5, хүүхдийн баяраар төв талбайд үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөл 43 тус тус олгосон.Хагас жилийн зөвшөөрөл хүссэн нийт 56 хүсэлт ирснийг 100% шийдвэрлэсэн.			
16		8.6.10. мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;	Мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагааны талаар мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан иргэдэд мэдээлж ажиллаж хэвшсэн. Энэ ажлын хүрээнд телевизийн нэвтрүүлэг 11 удаа, постор 77, үйл ажиллагааны талаар мэдээг байгууллагын цахим хуудсанд 400 орчим удаа нийтэлж, үйл ажиллагааг сурталчилж 30000 орчим хүнд хүргэж ажилласан.	100%	100%	
17		8.6.21. мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцаж байгаа суралцагч байхгүй.	100%	100%	
18		8.6.22. хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл. (8.6.Мэдээлэл хариуцагч энэ	Өөрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт,	100%	100%	

			хуулийн 8.2, 8.3, 8.4, 8.5-д зааснаас гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:)	хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, байгууллагын албан ёсны сайт, фэйсбүүк хуудас болон орон нутгийн BBS телевиз, Сүхбаатарын өнгө, Саунд ов фильм студитэй гэрээ байгуулан нээлттэй мэдээллэж, мэдээлэл хүссэн этгээдийг мэдээлэл авах боломжоор хангаж ажилласан.			
УИХ-ын тогтоол							
4	19	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2017-06-09 Дугаар 2017 №46	1.5.. Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс, сургалтын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, тухайн орон нутгийнхаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, сувилалд тэгш хамруулах асуудлыг тусгаж, үүрэгжүүлж ажиллах;	Тусгай хэрэгцээт иргэдийг соён гэгээрүүлэх, нийгэмшүүлэх, эрх хөгжил хамгааллыг нь дэмжих зорилготой хөдөлмөр эрхлэлт, эрүүл мэнд боловсрол, спорт, соёл урлагийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагатай "Тэгш боломжийг хамтдаа" уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Арга хэмжээнд аймгийн Үйлдвэрчний эвлэл, Гэр бүл сайн сайхны нийгэмлэг, Хөл бөмбөгийн холбоо, Шатрын холбоо, Сийлэнгоо эмэгтэйчүүдийн клуб, Ахмадын холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоо зэрэг иргэний нийгэмлэгийн 7 байгууллага болон 15 хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцож санал санаачилга, ажлын санал зэргийг хэлэлцэн ярилцаж хамтран ажиллах шийдвэрт хүрсэн. -БНСУ-ын Юмжин хараа зүйн төвийн эмч нар иргэдэд нүний үзлэг хийж харааны шил тааруулан ажилласан. Үзлэгт орох шаарлагатай 260 хүүхдийн нэрсийг жагсаалтаар гаргаж хувиарын дагуу үзлэгт хамруулах ажлыг зохион байгуулсан. -2-5 настай хүүхдийн нархан сувилалд хөгжлийнэ бэрхшээтнэй	100%	100%	

				20 хүүхдийг хамруулсан,			
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
5	20	Бэлгийн замаар дамжих халдварт өвчин, хүний дархлал хомсдолын вирусын халдварын тархалтыг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай 2016-12-14 Дугаар 2016 №04 НББСШУБХ	2.2/. Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж батлуулах, зарцуулалтад хяналт тавих.	Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахад зориулж 1,387,509,7 зардлыг 2023 оны төсөвтөө тусган батлуулан ажил, арга хэмжээ бүрд зарцуулан, гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.	100%	100%	
6	21	“Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл”-ийг хэлэлцсэнтэй холбогдуулан авах арга	3.8.. Бүх шатны Засаг дарга гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв, хөрөнгийг шийдвэрлэх, дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих,	Сумын ИТХ-ын 2022 оны 15/10 тоот тогтоолоор батлагдсан сумын 2023 оны төсөвт хамтарсан багийн үйл ажиллагаанд 5,000,000 төгрөгийг батлуулан ажиллаж байна. Сум багийн хамтарсан багийн дарга нарийн бичиг нарийг чадавхжуулах сургалтыг "Монгол өрх" сэтгэл зүйн хүрээлэнтэй хамтран "Хариуцлагатай хамтарсан баг" сургалт, Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 6 дугаар сарын 21-ны өдөр "Хүүхэд хамгаалал ба эрсдэл тодорхойлох" сургалтыг	100%	100%	

		хэмжээний тухай 2018-01-31 Дугаар 2018 №02 ХЗБХ	урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулахад анхаарах, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтарсан багийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах, хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, хорооны цагдаагийн алба хаагч, нийгмийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтныг ажиллуулах.	хамтарсан багийн дарга нарийн бичиг, хэсгийн байцаагч, эмч нарыг чадавхжуулах сургалтуудыг зохион байгуулсан. Сургалтад хамрагдсанаар хамтарсан багийн гишүүд дараах мэдээллүүдийн дагуу ажиллах чадамж эзэмшинэ. Үүнд: Хүүхэд хамгаалал, архидалт, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах хамтарсан багийн хуулиар тусгайлан хүлээсэн чиг үүргийн хүрээнд нэгдсэн ойлголт, нийтлэг горимоор урьдчилан сэргийлэх, шуурхай хариу үйлдэл үзүүлэх, харилцаа уялдаатай цогц, нөхөн сэргээх нийгэм сэтгэлзүйн үйлчилгээ үзүүлэх, зохицуулах, албажуулах, холбон зуучлах, эргэх холбоо тогтоох, хяналт үнэлгээ хийх гэх мэт харилцан давхцахгүй, орхигдохгүй оновчтой системээр ажиллах нэгдсэн ойлголт, арга зүйн зөвлөмжөөр хангана. • Нэгдсэн ойлголт, нэг үг хэллэг, заавал мэдэх 20 мэдлэг. • Асуудал бүрийг илрүүлэх, эрсдэлийг үнэлэх, хэлэлцэх, хариу үйлдэл үзүүлэх стандарт аргачлалаар хангасан. Хавсралт : 3 зураг			
7	22	Чиглэл өгөх тухай 2022-06-07 Дугаар 2022 №14 НББХ	1.6/. Улсын хэмжээнд сум бүрийг “Ахмадын өргөө”-тэй болгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, Ахмадын өргөөний урсгал зардал, тоног төхөөрөмжийг шийдвэрлэх, ажиллаж буй ахмадын урамшууллыг тухайн орон нутгийн төсөвт тусгаж, санхүүжүүлэх;	2020 оны Орон нутгийн 470 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Баруун-Урт сумын төвд ахмадын ордонд өргөтгөл барьж 2 давхар болгосон. Хагас жилийн байдлаар ахмадуудыг дэмжих нөөц санд 30,0 сая төгрөг төлөвлөсөн байна.	100%	100%	

8	23	Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ	1.1.4/. асрамж, халамжийн төв, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд ажиллах орон тооны сэтгэл зүйч, дохионы хэлний хэлмэрч, сэтгэл засалчийг ажиллуулах, онлайнаар тус үйлчилгээг авах нөхцөлөөр хангах;	Тус Тамгын газарт сэтгэлт зүйн төвийг нээн шаардлагатай тоног төхөөрөмж, өрөө, тасалгаа, мэргэжлийн боловсон хүчнээр ханган иргэдэд болон хохирогчдод сэтгэл зүйн зөвлөгөө өгч эхлээд байна.	100%	100%	
Ерөнхийлөгчийн зарлиг							
9	24	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх туй 2018-05-23 Дугаар 2018_46	3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиүлэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	2025 оноос төрийн албан хэргийг крилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих ажлын хүрээнд сумын хэлний бодлогын орон тооны бус зөвлөл нь 2023 онд хийх ажлын төлөвлөгөөгөө гарган батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу өөрийн харьяаны төрийн болон төрийн бус байгууллагуудын албан бичгийг хос бичгээр хослуулан бичиж хэрэглэхтэй холбогдуулан монгол бичгийн албан бланктай болсон байгууллагыг тоог гаргахад нийт 21 байгууллагын 16-н байгууллага нь хэвлэмэл албан бланктай болсон захирамж тушаал шийдвэрүүдийг хос бичгээр үйлдэн хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн байна. Өөрийн харьяаны 21 байгууллагуудын гадна хаяг болон дотор өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг хос бичгээр бичиж хэвлүүлсэн байрлуулсан байдалд хяналт хийхэд 16-н байгууллага гадна хаягаа монгол бичгээр бичиж байршуулсан 15 байгууллага өрөө тасалгааны хаягыг монгол бичгээр бичиж хаягжуулсан байна. Аймгийн НТБ төвтэй хамтран "Эх бичиг- Цахим орчинд" уралдааныг зохион байгуулж уралдаанд төрийн 12 байгууллагын	70%	70%	

				материал ирж 1 дүгээр сургууль, аймгийн Нийгмийн даатгал, Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр зэрэг газрууд амжилттай оролцлоо.			
10	25	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_23	1.1. Монгол Улсын сум, нийслэлийн хороо бүрийн төлөөллийг жигд хангаж, тухайн жилийн элсэлтийн ерөнхий шалгалтад харьяалах сум, хороондоо хамгийн өндөр оноо авсан тус бүр 1 иргэнийг дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлэгийн бэлтгэл хөтөлбөрт элсүүлэх.	Ерөнхийлөгчийн нэрэмжит дотоодын төрийн өмчийн их сургуулийн дэлхийн шилдэг их, дээд сургуульд суралцуулахад бэлтгэх, тэтгэлэгийн бэлтгэл хөтөлбөрийн журмын дагуу 2022-2023 оны хичээлийн жилд Баруун-Урт сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр бүрэн дунд сургуулийн 12 дугаар ангийн сурагч П. Мөнх-Учрал Элсэлтийн ерөнхий шалгалтад Математикийн хичээлээр 800 оноо, Англи хэлний хичээлээр 796 оноог тус тус авч тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах эрхээ авлаа. Дээрх суралцагч нь эхний нэг жилдээ эх орондоо хэлний бэлтгэлд хамрагдаж / ОХУ, БНХАД, БНСУ, АНУ/ 100 хувийн тэтгэлгээр суралцах юм.	100%	100%	
11	26	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	1.6. Дүүрэг, сумдад ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж бүх нийтийн үйлс болгох	Ногоон байгууламж бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулж, иргэдэд мод тарих соёлыг сурталчлан түгээж, бүх нийтийн үйлс болгох ажлын хүрээнд Баруун-Урт сумын Засаг даргын А/42 тоот захирамжаар аж ахуй нэгж байгууллагын хуваарийг баталж, мод тарих ажлыг зохион байгуулсан.Үүнд: - Багийн нутаг дэсвгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгжүүдэд 1/193 тоот албан бичгийг хүргүүлж, байгууллагын орчинд мод тарихыг үүрэг болгосон.Үүний дүнд 70 аж ахуй нэгж 33257ш мод тарьсан. -Боловсролын нэрэмжит төглийн хашааг сунгаж, Асгатын зам дагуу 1 га газрыг хашаажуулсан. Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн боловсронгуй болгох төслийн санхүүжилтээр Баруун-Урт сумын 2 дугаар багийн	100%	100%	

				<p>нутаг дэвсгэрт Баруун-Уртын голын ай савд 8 га газарт ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх газрыг хашиж, 250 бургас тарьсан. -ХАА-н цогцолборт 5000 ш модыг тарьж, хашаа, хайс хамгаалалтын ойн зурвас байгууллаа. 2023 онд хаврын тарилтаар 70 аж ахуй нэгж байгууллага 33257 мод, 600 иргэн хуваарьт болон эзэмшил газартаа 1000 ш, нийт 34257 модыг тариад байна.</p> <p>Хавсралт : 5 файл</p>			
	27		<p>2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.</p>	<p>Мод тарих ажлыг бүх нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлэх ажлын хүрээнд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон байгууллагын цахим хуудсаар дамжуулан эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудыг уриалж , 05 дугаар сарын 13-ны өдөр аймгийн БОГазартай хамтран Сүхбаатарын төвд талбайд нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд 70 байгууллага, 600 иргэн идэвхтэй хамрагдаж 34257 мод тарьсан.</p>	100%	100%	
12	28	<p>Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159</p>	<p>2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.</p>	<p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн 159 тоот зарлигийг аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг сумын Засаг дарга, ИТХ-ын төлөөлөгч нар төр төлөөлөн оролцож, Ерөнхий боловсролын 4 сургууль, 11 цэцэрлэгийн 2022-2023 оны хичээлийн шинэ жилийн нээлтийн үеэр Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн байгууллага дээрээ залсан.</p>	100%	100%	

				Хавсралт : 5 зураг			
ҮАБЗ-ийн зөвлөмж							
13	29	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-09-30 Дугаар 2021_03	3.5. Байгаль орчноо хайрлан хамгаалах, зохицон амьдрах, монгол зан заншлыг дээдлэх, уур амьсгалын нөлөөллийг бууруулах, ой мод, усны нөөцийг хамгаалах, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор экологийн боловсролыг бүх шатны боловсролын байгууллага болон хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан бүх нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ авах.	Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газраас хог хаягдлыг ангилан ялгах дадал хэвшлийг бий болгох, орчны бохирдол үүсэхээс сэргийлэх, экологийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор Гэрэлт ирээдүйн төлөө аюулыг авдарлая аянг 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулан.Тус аянд нэгдэж Баруун-Урт суманд үйл ажиллагаагаа явуулдаг 8 байгууллага нэгдсэн. Цэцэрлэгийн хүүхдийн өдөр тутмын сургалт үйл ажиллагаа, ариун цэвэр сахих үед гардаг хогны ихэнх хувь нь цаасан хог хаягдал байдаг учир цаас хаях зориулалтын тэмдэглэгээтэй саванд хийж хэвшиж байна. “Аюулыг авдарлая” уриан дор давхардсан тоогоор нийт 276 эцэг эх, 23 багш ажилтанд аюултай хог хаягдлын хор уршигийг таниулах тараар мэдээлэл өгч ажиллалаа. ЕБСургууль, МСҮТөвийн багш, сурагчдыг хамруулан 800 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр дараах 5н байршилд нийтийн цэвэрлэгээг зохион байгууллаа. Хог зөөврийг Сүхбаатар тохижилт-Үйлчилгээ ОНӨҮГазраас 2 машин, 3 ачигчтай хийж, нийт 6 машин хогийг хогийн нэгдсэн цэгт зөөвөрлөсөн. Аймгийн Байгаль хамгаалах сангийн санхүүжилтээр экологийн боловсролыг олгох, хог хаягдлыг ангилах талаарх мэдээллийн самбарыг хүлээн авч хогийн нэгдсэн цэгт байршуулах ажлыг хийж байна.	100%	100%	
ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл							

14	30	Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах тухай 2010-03-18 Дугаар 2010_10/03	6. . Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгийн үед авран хамгаалах, сэргээн босгох үйл ажиллагааны төлөвлөгөө, хамтарсан гэрээ, бүх нийтийг хамарсан иргэний хамгаалалтын албан ба албан бус сургалтын хөтөлбөр боловсруулж, сургуулилт зохион байгуулж хэвших, (Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Зэвсэгг хүчний жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга)	Монгол Улсын Засгийн газрын 339, 340 дүгээр тогтоолоор "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд газар хөдлөлтийн дадлага сургалтыг 2023 оны 06-р сарын 08-ны өдрийн 16:00 цагт Баруун-Урт сумын иргэдийг газар хөдлөлтийн үед аюулгүй талбайд 11 цэгт байршуулж нийт 9 багийн 2212 том хүн 343 хүүхэд тус сургуульд хамрагдсан ба төлөвлөлт, үеийн дадлага сургуулийн үеэр нийт иргэдэд “Бэлэн бай” апплейкешнийг суртачилан таниулсан.Тус ажлыг Баруун-Урт сумын онцгой комисс, ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, багийн ажлын алба хамтран зохион байгуулсан. Улс орон даяар Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр команд штабын сургуулийг ОБЕГазраас зохион байгуулж тус сургалтад аймгийн Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний багт 4 албан хаагч орж сургалтад хамрагдсан.	100%	100%	
	31		11.. Барилга, хот байгуулалтын хууль, төлөвлөлтийн норм, дүрэм, журам, стандартын нөхцөл шаардлагыг зөрчсөн дутагдлыг арилгах, ялангуяа Улаанбаатар хотод ерөнхий төлөвлөгөөнд тусгагдаагүй барилга барих, байшин хоорондын зайд норм зөрчин газар олгох явддыг таслан зогсоох, (Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга)	Баруун-Урт сумын Гамшгийн эрсдлийн нарийвчилсан үнэлгээг хийж байгаатай уялдуулан Баруун-Урт сумын нутаг дэвсгэрт байрлах нийтийн эзэмшлийн болон хувийн орон сууцнуудын судалгааг Аймгийн газрын харилцаа барилга хот байгуулалтын газар хийж гүйцэтгэж байна. Мөн Газар олголтын асуудалд хяналтын тавьж ажиллаж байна.	70%	70%	

ЗГ-ын тогтоол

15	32	<p>“Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээг батлах тухай 2021-06-01 Дугаар 2021_161</p>	<p>3. “Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж” төсөл, арга хэмжээний хүрээнд сумдын Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж ажиллахыг холбогдох аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.</p>	<p>Нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох, инженерийн дэд бүтцийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулах зорилгоор тус сумын харьяа Сүхбаатар тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГазар, Уртын гэгээ ОНӨААТҮГазрын бүтэц орон тоо нийт 17 албан хаагчаар нэмэгдүүлэн ажиллах нөхцөлийг бүрдүүлж ажилласан. Сүхбаатар тохижилт, үйлчилгээ ОНӨААТҮГазар нь тус сумын хот тохижилт, хог хаягдлын менежментийг сайжруулах, хотын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх, иргэдийн ая тухтай амьдрах орчин нөхцөлийн бүрдүүлэх, зам болон замын байгууламжийг хариуцан ажилладаг. Уртын гэгээ ОНӨААТҮГазар нь тус сумын гэрэлтүүлэг, нийтийн эзэмшлийн орон сууц болон хотхон хорооллын цэвэрлэгээ, үйлчилгээ, засвар, ухуулга, сурталчилгааны самбарын шинэчлэл, хадгалалт, хамгаалалт, тоглоомын талбайн засварыг тус тус хариуцсан ажиллаж байна.</p>	70%	70%	
16	33	<p>Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7</p>	<p>5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг</p>	<p>5.2. заалт Сумын Засаг даргын тамгын газрын дэргэдэх Хэлний бодлогын орон тооны бус салбар зөвлөл нь аймгийн НТБ төвтэй хамтран " Эх бичиг-Цахим орчинд" уралдааныг зохион байгуулж уралдаанд төрийн 12 байгууллагын материал ирж 1 дүгээр сургууль, аймгийн Нийгмийн даатгал, Боловсрол өргөө нэгдсэн дотуур байр зэрэг газрууд амжилттай оролцлоо. 5.3. заалт 2025 оноос төрийн албан хэргийг крилл болон монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих ажлын хүрээнд сумын хэлний бодлогын орон тооны</p>	70%	70%	

			<p>зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.</p>	<p>бус зөвлөл нь 2023 онд хийх ажлын төлөвлөгөөгөө гарган батлуулан ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу өөрийн харьяаны төрийн болон төрийн бус байгууллагуудын албан бичгийг хос бичгээр хослуулан бичиж хэрэглэхтэй холбогдуулан монгол бичгийн албан бланктай болсон байгууллагыг тоог гаргахад нийт 21 байгууллагын 16-н байгууллага нь хэвлэмэл албан бланктай болсон захирамж тушаал шийдвэрүүдийг хос бичгээр үйлдэн хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж эхэлсэн байна. 5.4. заалт Орон тооны бус салбар зөвлөл нь төлөвлөгөөний дагуу сумын харьяаны ерөнхий боловсролын 4 сургууль, 11-н цэцэрлэг, ӨЭМ-2 төв Орон нутгийн өмчит ААТҮГ болон сумын тамгын газрын нийт 820 гаруй албан хаагчдаас монгол бичгийн түвшин тогтоох шалгалтыг авч нийт албан хаагчдын 10 хувь ахисан шатны мэдлэгтэй, 60 хувь дунд шатны мэдлэгтэй, 30 хувь анхан шатны мэдлэгтэй байна. 5.5. заалт Өөрийн харьяаны 21 байгууллагуудын гадна хаяг болон дотор өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг хос бичгээр бичиж хэвлүүлсэн байрлуулсан байдалд хяналт хийхэд 16-н байгууллага гадна хаягаа монгол бичгээр бичиж байршуулсан 15 байгууллага өрөө тасалгааны хаягыг монгол бичгээр бичиж хаягжуулсан байна.</p> <p>Хавсралт : 14 зураг</p>			
17	34	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-01-11	<p>3. Хяналт шалгалтын үйл ажиллагаанд шаардагдах зардлыг 2023 оны батлагдсан төсөвтөө багтаан, шаардлагатай бол зохицуулалт хийн санхүүжүүлж, цаашид</p>	<p>Хяналт шалгалтын үйл ажиллагааг байгууллагын эрх хэмжээний хүрээнд чиглэлийн дагуу хийж, зөвлөгөө өгч ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс</p>	30%	30%	

		Дугаар 2023_79	холбогдох эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд батлуулж байхыг Засгийн газрын холбогдох гишүүд, Сангийн сайд Б.Жавхлан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.			
18	35	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_55	1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай	1. Аймгийн Засаг даргын А/468 тоот захирамжаар эрх шилжиж ирсэн Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын дээвэр засварын ажлыг / Одкон хотхон 1,2 дугаар байр, 27 в байр / 2022 онд 1 удаа зарлаж амжилтгүй болж 2023 онд 1 удаа зарлаж гүйцэтгэгчээр Нар сар газар ХХК 167,192.9 мянган төгрөгөөр шалгарч ажлыг А/159 тоот захирамжаар хүлээн авсан. 2. Зуны сувилал байгуулах ажлын хүрээнд зөөврийн сууц худалдан авах ажлыг tender.gov.mn сайтаар зарлан зохион байгуулж гүйцэтгэгчээр Оточ оргил ХХК 119,800,000 төгрөгөөр шалгарч бараа хүлээн авсан. 3.Нэгдсэн систем нэвтрүүлэх камержуулалтын нэгдсэн тоног төхөөрөмж худалдан авах ажлыг tender.gov.mn сайтаар зарлан зохион байгуулж тендерт 5 компани оролцож үүнээс Топика ХХК 124,271.3 мянган төгрөгийн үнийн саналаар шалгарч гэрээ байгуулах шатандаа явагдаж байна. 4. Ундны ус нөөцлөх 1000м3, 2000м3 усан санг доторлох, битүүмжлэл сайжруулах ажил дээр сумын засаг даргын А/152 тоот захирамжаар байгуулаад байна. Аймгийн засаг даргын захирамжаар эрх шилжиж ирсэн 4 ажлын биелэлт 75 хувьтай байна. Сумын 2023 оны батлагдсан төсөл арга хэмжээний хүрээнд: - Шууд худалдан авалтын журмаар 10 ажил, - Харьцуулалтын аргаар 10 ажил, - Нээлттэй тендер	70%	70%

				шалгаруулалтын журмаар 2 ажлыг тус тус tender gov.mn сайтаар 100 хувь цахимаар зарлан зохион байгуулсан. Нийт 21 ажлын 957,250.6 мянган төгрөгийн гэрээ байгуулж 345,144.6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.			
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
19	36	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	XIX.6.2. “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлтийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	Тамгын газрын Иргэдэд үйлчлэх төвд төрийн үйлчилгээний оператор ажиллуулж байна. Тайлант сарын хугацаанд оператор нь төрийн үйлчилгээний системээс 41 төрлийн үйлчилгээг 997 иргэнд үзүүлсэн бөгөөд хамгийн их эрэлттэй үйлчилгээ нь нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх лавлагаа байна. Хоршоо хөгжүүлэх сангийн зээлдэгчдийн мэдээллийг Монгол банкны нэгдсэн системд оруулж, бусад арилжааны банкны мэдээллийн сантай холбогдсон. Төрийн үйлчилгээг иргэдэд цаг хугацаа, орон зай үл харгалзан тэгш хүртээмжтэй хүргэх ажлыг шат дараатай зохион байгуулж байна. Тус сумын улсын бүртгэгч нь 10 төрлийн бүртгэлийн үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй шуурхай хүргэж байгаагаас 2 үйлчилгээг цахимаар үзүүлж байна. Үүнд -Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл -Хаясан гээсэн иргэний үнэмлэх захиалах Мөн нийгмийн халамжийн 72 төрлийн үйлчилгээ цахим бүрэн шилжсэн. Үр дүнд нь 107 үйлчилгээг иргэд байгаа газраасаа шуурхай авах боломжтой болсон. 2023 оны 1 дүгээр улирлаас Үйлчилгээний нэгдсэн төвд газрын харилцааны киоск машин нэвтрүүлсэн. Уг үйлчилгээг нэвтрүүлснээр газрын харилцаатай холбоотой 70 төрлийн үйлчилгээ, 12 төрлийн лавлагаа мэдээлэл, 52 төрлийн өргөдөл гаргах үйлчилгээг цахимаар авах боломжтой болсон.	70%	70%	

				2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр хийж хэрэгжүүлэх ажлын саналыг иргэдээсээ авч эрэмбэлэн, 2023 оны үндсэн чиглэл, мөрийн хөтөлбөртэй уялдуулан нийт 48 нэр төрлийн ажил хийхээр төлөвлөн ажиллаж байна.			
20	37	2023 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр 2 дугаар тэмдэглэл 2023-01-05 Дугаар 2023_2	IV.2.3. хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан олгох болсонтой холбогдуулан иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий хамтарсан багийг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд аймаг, дүүрэг, сум, хороонд байгуулан ажиллуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;	Хүүхдийн мөнгийг өрхийн амьжиргааны түвшинтэй уялдуулан олгох болсонтой холбогдуулан иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх чиг үүрэг бүхий хамтарсан багийг сумын Засаг даргын захирамжаар байгуулсан. Хүүхдийн мөнгөтэй холбоотой биеээр ирсэн 59, утсаар холбогдсон 55, цахимаар хандсан-21 нийт 135 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа. Мөн 2022 оны хүүхдийн мөнгөний нөхөн олголт хийгдэхтэй холбоотой 68 хүүхдийн мэдээллийг тулгаж 18 хүүхдийн нөхөн олголтыг холбогдох мэргэжилтэнд хүргүүлж ажилласан.	100%	100%	
ЗГ-ын албан даалгавар							
21	38	2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай 2022-08-01 Дугаар 2022_9	3. 3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт: 3.1. “Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 20-ны өдрийн 277 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд аймаг,	Баруун-Урт сум нь хадлангийн тоног төхөөрөмжийг түрээслэн сумын аюулгүй нөөцөд 800 боодол буюу 16 тн өвс, Гамшгаас хамгаалах зардлаас 34.0 сая.төгрөгийг зарцуулж Дорнод аймгийн гурилын үйлдвэрээс 1590 шуудай буюу 43,1 тн тэжээл, өөрийн ХАА-н цогцолборт тариалсан 200 боодол буюу 7 тонн ногоон тэжээлийг хураан авч хадгалах цэгт байршуулсан. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд тавих хяналт тавьж нийт 100,0 сая.төгрөгийн санхүүжилт орсон байна. Тус сумын 9 багийн 669 хот айлын 1089 малчин өрхийн нийт	100%	100%	

		<p>нийслэл, сум, дүүргийн хэмжээнд бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөц"-ийг тогтоосон хэмжээнд бүрдүүлж ажиллах; 3.2. Хөдөө аж ахуйн салбарын 2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах; 3.3. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хүн амыг чанарын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой, хүртээмжтэй хангах, өвөл, хаврын улирлын хэрэгцээнд шаардагдах махны нөөцийг бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэх, нөөцийн махны чанарт онцгой анхаарч ажиллах; 3.4. Малын арьс, ширэнд анхан шатны боловсруулалт хийлгэж, Хөдөө аж ахуйн биржээр арилжаалах зохион байгуулалтын арга хэмжээ авах; 3.5. Аймаг, сумын хэмжээнд орон нутгийн тусгай хэрэгцээний отрын нөөц газрын хил заагийг тодорхойлж, харьяалах аймаг, сумдад өвөлжүүлж, хаваржуулах ажлыг зохион байгуулах; 3.6.</p>	<p>533734 толгой мал / тэмээ 497, адуу 52482, үхэр 46289, хонь 268597, ямаа 165869/ өөрийн аймгийн 6 сумын нутаг дэвсгэрт отроор өвөлжсөн. Сумын нутаг дэвсгэрт 2 инженерийн хийцтэй худаг гаргасан. 3.8. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэх зорилгоор 2021, 2022 оны татварын үлдэгдэл 75,0 сая. төгрөгийн орлого төвлөрүүлэх ажлыг хийж байна. Тус сумын 9-н багийн 669 хот айлын 1089 малчин өрхийн нийт 533734 толгой мал / тэмээ 497, адуу 52482, үхэр 46289, хонь 268597, ямаа 165869/ өөрийн аймгийн 6 сумын нутаг дэвсгэрт отроор өвөлжиж, хаваржиж байна. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн газрын малчин өрхүүдэд ОУБ-тай хамтран 45 өрхөд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлсэн. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд татвар хураалтын ПОСС машин 2 ш худалдан авч татварын улсын байцаагч, 8-р багийн ажлын албанд хүлээлгэн өгч, татвар татан төвлөрүүлэх ажил хийгдэж байна. 3.9. 5-р сарын 19-ны өдрийн байгалийн гамшигт үзэгдлийн улмаас тус сумын малчдын нутаглаж буй нутаг дэвсгэрт салхины хүч 30 м/с хүрч шороон болон цасан шуурга 4-5 цаг үргэлжилж гамшгийн хэмжээнд хүрсэн. Цаг агаарын гамшигт үзэгдлийн улмаас 49181 толгой мал хорогдсон урьдчилсан мэдээтэй байна. Хохирлыг тогтоох, устгалын ажлыг зохион байгуулсан. Уг ажилд 5 группэд 25 албан хаагч 5 хүнд механизм ажиллаж 12 цэгт устгалын ажлыг зохион байгууллаа.</p>			
--	--	---	--	--	--	--

		<p>Хадлангийн талбайг оновчтой хуваарилах, зохистой ашиглах асуудлын хүрээнд говийн бүсийн болон хадлангийн нөөц багатай аймгуудад хадлан, гар тэжээл бэлтгэхэд нь зохих дэмжлэг үзүүлж ажиллах; 3.7. Орон нутагт хийгдэж байгаа инженерийн хийцтэй худгийн чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах; 3.8. Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлэх, орлого бүрдүүлэлтэд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах; 3.9.</p> <p>Цаг агаарын хүндрэл, болзошгүй гамшиг тохиолдохоос урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг хууль тогтоомж, батлагдсан төлөвлөгөөний дагуу шуурхай авч хэрэгжүүлэх; 3.10.</p> <p>Ургацын урьдчилсан балансыг таримлын төрөл бүрээр 8 дугаар сарын 18-ны дотор нарийвчлан гаргаж, таримал ургамлыг ургамлын өвчин, хөнөөлт шавжаас хамгаалах, урьдчилан сэргийлэх арга ажиллагаа, ургац хураалтын үед баримтлах технологийн</p>				
--	--	---	--	--	--	--

		<p>ерөнхий зөвлөмжөөр тогтмол хангаж, ургац хураалтын мэдээ, тайланг үнэн зөв гаргах;</p> <p>3.11. Газар тариалангийн мэдээллийн нэгдсэн санд тариаланчид, тариалангийн талбай, ургацыг бүртгэх цахим системийг нэвтрүүлж, гарал үүслийн гэрчилгээг цахимаар олгох ажлыг зохион байгуулах;</p> <p>3.12. Ургацыг малаас хамгаалах, ургац хураалтын ажил дуусах хүртэл тариалангийн талбайн ойр орчимд малчин, мал бүхий этгээдийг суурьшуулахгүй байх, малыг байнгын хариулгатай байлгах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;</p> <p>3.13. Сортын үрийн хянан баталгааг хугацаанд нь хийх, дараа оны тариалалтад зориулан нөөцлөх үрийн цэвэрлэгээг шалгаж, стандарт шаардлагад нийцүүлэх, ногооны зоорь, агуулах, үтрэмийн цэвэрлэгээ, ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад байнгын хяналт тавьж ажиллах;</p> <p>3.14. Төвлөрсөн хот, суурин газар, төв замын дагуу төмс, хүнсний ногооны борлуулалтын цэг ажиллуулахад дэмжлэг</p>			
--	--	---	--	--	--

			үзүүлэх;				
--	--	--	----------	--	--	--	--